



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/419

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, 11.1.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоол, 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 6/04 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Эмч” дэд хөтөлбөрийг эрүүл мэндийн салбар болон олон нийтэд мэдээлэх, сурталчилах, явцын үнэлгээ хийх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 2000000 /Хоёр сая / төгрөгийг аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн “Хуваарилалт хийх тухай” А/306 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Эмч дэд хөтөлбөрийн сурталчилгаа, олон нийтэд мэдээлэх, хөтөлбөрийн явцын үнэлгээ хийх зардал”-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т даалгасугай.



Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны  
07 дугаар сарын 07-ны өдрийн  
47.19 дугаар захирамжийн хавсралт

### ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд
1	Гарын авлага бэлтгэх	900	1800	1620000
2	Үнэлгээ хийх, уулзалт хийх ажлын хэсгийн зардал	1	380000	380000
	Нийт			2000000